



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 11,732,000.00 (арван нэгэн сая долоон зуун гучин хоёр мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Үндэсний статистикийн хороонд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Монгол банкны Тамгын газрын захирал Г.Пүрэвсүрэн, Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 08 дугаар сарын 1-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ БАНКНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНД  
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн (ашиглалтад) орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)
1	Суудлын автомашин TOYOTO LAND CRUISER J200 JTMHU09J205000687, улсын дугаар 0613 УБЗ	2007/2011	310,789	11,732,000.00	3
НИЙТ ҮНЭ					11,732,000.00 (арван нэгэн сая долоон зуун гучин хоёр мянга)